



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 60

Мандалговь

Хөрөнгө дансанд бүртгэх
зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3-ын "б" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сайнцагаан сумын 7-р цэцэрлэгийн 2 нэрийн 6,310,000 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тус байгууллагын дансанд бүртгэх зөвшөөрөл олгосугай.

2. Орлогодох хөрөнгийн холбогдох бичиг баримтын бүрдлийг журмын дагуу хангаж дансанд бүртгэхийг 7-р цэцэрлэгийн нягтлан бодогч (Н.Энхмарт)-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг 7-р цэцэрлэгийн эрхлэгч, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга нарт даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ